

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД, “ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧИЙГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНЫ 14 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 10 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдаас Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг 2014 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо дээрх төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтцийг өөрчилснөөр яамдын үйл ажиллагааны давхардлыг арилгах, үйл ажиллагааг шуурхай болгох, илүүдэл орон тоог цөөрүүлж, төсөв хэмнэх, төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, зохион байгуулах ажилд ахиц гарч, иргэдэд ил тод, нээлттэй, шуурхай үйлчлэх нөхцөл бүрдэнэ гэж үзжээ.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах зорилгоор Засгийн газрын яамдын бүтцийг оновчтой тогтоож, чиг үүргийн давхардалгүй ажиллах үүднээс Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамыг нэгтгэн Сангийн яам; Уул уурхайн яам, Эрчим хүчний яамыг нэгтгэн Геологи, уул уурхай, эрчим хүчний яам; Барилга хот байгуулалтын яам, Зам тээврийн яамыг нэгтгэн Дэд бүтцийн хөгжлийн яам болгон өөрчилж, 13 яамтай байхаар төслөө боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд Засгийн газарт бүтцийн өөрчлөлт биш, сайд нарын сэлгээ хийх нь зүйтэй, эдийн засгийн гол яамдыг нэгтгэсэн нь оновчтой бус, төрийн үйлчилгээний салбарт орон тооны цомхотгол хийхгүй байхыг анхаарах; Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан төрийн эрх, үүргийн хуваарилалтыг судалгаанд тулгуурлан зөв хийх, Монгол Улсын Үндсэн хуульд заавал

байх 7-8 яамыг тусгаж, 3-4 яамыг сонгуульд ялсан улс төрийн хүчин мөрийн хөтөлбөрийн онцлогоос шалтгаалан шинээр байгуулж байх; Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт Засгийн газрын бүтцийг тогтвортой байлгах зорилгоор Улсын Их Хурлын нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар бүтцийг өөрчлөхөөр холбогдох хуульд тусгах, Ерөнхий сайдын дэргэд эдийн засгийн бодлого, хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх Эдийн засгийн хөгжлийн хороо байгуулж, Эдийн засгийн хөгжлийн яамыг, Сангийн яамтай нэгтгэж байгаа нь зүйтэй, түүнчлэн “Дэд бүтцийн хөгжлийн яам” гэснийг “Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам” гэж, “Геологи, уул уурхай, эрчим хүчний яам” гэснийг “Уул уурхай, эрчим хүчний яам” гэж тус тус өөрчлөх; Улсын Их Хурлын гишүүн Сү.Батболд Засгийн газрын бүтцийг өөрчилж боловсронгуй болгохдоо төрийн бодлого, үйл ажиллагааны залгамж чанарыг алдагдуулахгүй байх; Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл бүтцийн өөрчлөлтийг хийж буй реформтой уялдуулах асуудлыг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргалаа.

Эдгээр хуулиуд батлагдснаар зарим яамдын эрхлэх асуудлын хүрээнд орох өөрчлөлттэй уялдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамтад нь өргөн мэдүүлэх нь зүйтэй гэсэн чиглэлийг Засгийн газарт өгөв.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А. БАКЕЙ